

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
2024 ОНД ХЯНАЛТАД АВАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД БОЛОН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 01 дүгээр сарын 15

Багахангай дүүрэг

Нэг. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, үр дүн

Дүүргийн хэмжээнд 2024 онд дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, жилийн эцсийн байдлаар 96,6 хувьтай,
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 5 арга хэмжээний хэрэгжилтийг 6 удаа тайлагнаж, дундаж биелэлт 55 хувьтай,
- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилт, жилийн эцсийн байдлаар 50 хувьтай,
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хэрэгжилт, жилийн эцсийн байдлаар 93,3 хувьтай,
- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөнөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 25 арга хэмжээг түүвэрлэн хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар 79,6 хувьтай,
- Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээг түүвэрлэн хэрэгжилтийг ханган жилийн эцсийн байдлаар 84 хувьтай,
- Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багахангай дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 73 заалтын хэрэгжилтийг ханган, жилийн эцсийн байдлаар 92,9 хувьтай,
- Тус онд Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль болж дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссантай холбогдуулан 6 бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 139 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулсан хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXX хуралдаанд танилцуулахад 93,6 хувьтай тус тус хэрэгжлээ.

Хоёр. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

а) Засгийн газрын тогтоол, албан даалгавар, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилт:

- Монгол Улсын Засгийн газрын 17 тогтоолоор өгөгдсөн нийт 20 арга хэмжээний дундаж биелэлт 63,5 хувь,
- Монгол Улсын Засгийн газрын 7 хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн нийт 13 арга хэмжээний дундаж биелэлт 72,5 хувь,
- Монгол Улсын Засгийн газрын болон Ерөнхий сайдын нийт 2 албан даалгаврын биелэлт 100 хувь буюу дээрх тогтоол шийдвэрүүдийн дундаж биелэлт 78,7 хувьтай хэрэгжлээ.

б) Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр, Засаг даргын захирамж, Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, албан даалгавар, Онцгой комиссын шийдвэр, Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 тогтоолын дундаж биелэлт 92,5 хувь,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн нийт 4 арга хэмжээний хэрэгжилт 92,5 хувь,
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны Ажлын хэсэг байгуулах тухай захирамжуудаас эхний хагас жилийн байдлаар тус дүүрэгт хамаарах нийт 12 захирамжийг хяналтад авч, карт нээн бүртгэж, удирдлагуудад танилцуулан, биелэлтийг нэгтгэн тайлагнахад 90,9 хувьтай, 3 дугаар улирлын байдлаар Ажлын хэсэг байгуулах тухай нийт 15 захирамжийг хяналтад авч, биелэлтийг нэгтгэн тайлагнахад 91,3 хувьтай, жилийн эцсийн байдлаар Ажлын хэсэг байгуулах тухай болон түүвэр нийт 48 захирамжийн хэрэгжилтийг ханган, биелэлтийг тайлагнахад 96 хувьтай,
- Нийслэлийн Засаг даргын 2024 онд 3 албан даалгавраар өгсөн нийт 25 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнахад 100 хувьтай,
- Нийслэлийн Онцгой комиссын 2024 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, хэрэгжилт 100 хувьтай,
- 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан нийслэлийн Удирдах ажилтны 23 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн нийт 162 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, дундаж биелэлт 95,1 хувьтай тус тус хэрэгжлээ.

в) Дүүргийн Онцгой комиссын албан даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилт:

- Дүүргийн Онцгой комиссын 2024 оны “Халиа дошин, шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар, хэрэгжилт 100 хувь,
- Дүүргийн Онцгой комиссын 2024 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, хэрэгжилт 100 хувь,
- Дүүргийн Засаг даргын 2024 оны Ажлын хэсэг байгуулах тухай 73, түүвэр 144 нийт 217 захирамжийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94 хувьтай тус тус хэрэгжлээ.

--- оОо ---